



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2016 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Үүрэг хариуцуулах тухай

1. Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасныг үндэслэн Засгийн газрын зарим гишүүнийг томилох хүртэл хугацаанд тэдгээрийн үүргийг дор дурдсан хуваарийн дагуу хариуцуулсугай:

1.1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдад;

1.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад;

1.3. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад;

1.4. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдын үүргийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад.

2. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан үүргийг Засгийн газрын гишүүдийг нөхөн томилох хүртэл хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу хариуцан гүйцэтгэж байхыг сайд нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ